

ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХҮНД МАШИН, МЕХАНИЗМ АШИГЛАХ ШААРДЛАГА, БОЛОМЖ

Ш.Одхүү

*Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Онцгой байдлын хэлтсийн Гал
түймрийн Улсын хяналтын байцаагч, хошууч докторант*

Хураангуй : Манай улс ой, хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд орчин үеийн техникийн дэвшлийг нэвтрүүлснээр, түймрийн аюулын хор уршгийг арилгахад, хүн, хүч цаг хугацааг хэмнэх олон талын ач холбогдолтой юм. Хэдийгээр энэ асуудлыг шийдвэрлэхэд улс орны эдийн засгийн нөхцөл байдал, нөөц боломжоос шалтгаалж байгаа боловч, шаардлагатай тохиолдолд уул, уурхай, батлан хамгаалах чиглэлийн техникүүдийг ашиглах боломжтой эсэхийг судлах шаардлагатай байна. Судлаач миний бие 2017 оны ой, хээрийн түймрийг унтраах үйл ажиллагаанд ашигласан уул, уурхайн хүнд машин, механизм болон цаашид практикт ашиглахаар засварлан тохируулж байгаа ойн бүсэд шороон зурвас татагч хосолмол ажиллагаатай ПКЛ загварын анжсыг танилцуулж байна.

Оршил : Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, нүүрсхүчлийн хийг өөртөө шингээж, хүчилтөрөгч ялгаруулдаг, хөрсний эвдрэлээс хамгаалдаг, газрын гүний усыг өөртөө татаж газрын гадаргын усны эх үүсвэрийг бүрдүүлэгч ойг түймрээс хамгаалах үйл ажиллагаа нь Монгол Улсын төдийгүй дэлхий нийтийн тулгамдсан асуудал билээ.

Ой, хээрийн түймэр унтраах үйл ажиллагаанд хүнд машин, механизм ашиглах шаардлага :

Дэлхийн уур амьсгалын дулаарал сүүлийн 10 жилд дунджаар 1,8-2,2 градусаар дулаарч Монгол оронд түймрийн хуурайшилтын нэн их аюултай үе 2005-2010 онуудад 4-6 дугаар саруудад тохиож байсан бол 2014-2017 онуудад 4-8 дугаар саруудад хур тундасгүй 38-40 хэм хүртэл дулаарч гантай байснаас шалтгаалан ой, хээрийн түймрийн түймэр их гарсан. Хур тундасгүй хэт их халуун байснаас хөрсний гадаргуун түймэр, хөрсний гүний түймрийн хэлбэрт шилжиж унтраах үйл ажиллагаа удааширч, шатлагын талбай ихсэж байсан. Одоогоор орон нутгийн Онцгой байдлын байгууллагад ой, хээрийн түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд хүрз, троссон шүүр, 6 MF-35 загварын үлээгч аппарат, АЗ-4,5 маркийн цуравдагч, Ермак

РП-18 загварын үүргэвчийн ус шүршигч (РЛО) зэрэг гар багаж, төхөөрөмжийг ашиглаж байна. Ойн түймэр унтраах үйл ажиллагаанд Ермак РП-18 загварын үүргэвчийн ус шүршигчийг ашиглахад уулархаг газар гол, горхи усны эх үүсвэр ховор тул туулах чадвар сайтай ус тээвэрлэгч автомашины дэмжлэг шаардлагатай байдаг.

Үлээгч аппаратыг тал хээрийн түймэрт ашиглахад түймрийн фронтын шатаж буй өвсийг дотогш 0,5-1 метр хүртэл үлээдэг тул нэн тохиромжтой харин ойн түймэрт шатаж буй шар өвсөн дунд унасан мод, мөчир ихтэй байдгаас шалтгаалан унианг ихтэй ойн түймрүүдэд хэрэглэхэд тохиромжгүй байдаг.

Ой, хээрийн түймэр унтраах үйл ажиллагаанд хүнд машин, механизм ашиглах боломж: Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутаг дэвсгэрт 2017 онд 27 удаагийн ой, хээрийн түймэр гарч Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штаб, төв, орон нутгийн онцгой байдлын анги байгууллагуудаас нийт 485 албан хаагч 45 хоног ажилласан. Дээрх түймрүүдийг унтраах ажиллагаанд хөдөө аж ахуйн газар тариалангийн зориулалттай анжист 5 тракторуудыг дайчлан ажиллуулсан боловч ойн хөрсөнд анжисны боолт тасрах, хутга гулзайх зэрэг гэмтэл их гарч байснаас төдийлөн үр дүнд хүрээгүй, харин Бороо гоулд ХХК-аас бульдозер, автогридерийг Эрээний ам, Хуст, Цогт өндөр уул зэрэг ойн сан бүхий газруудад гарсан тус бүр нь 30-50 га 3 удаагийн ойн түймрийг унтраах үйл ажиллагаанд дайчлан ажиллуулахад ямар нэгэн техникийн сааталгүйгээр тулах шороон зурвасыг 1-3 хоногт татаж түймрийг 4-5 хоногийн хугацаанд хүн, хүч хэмнэн цураманд оруулан унтрааж байсан. Туршилт: Ойн бүсэд



шороон зурвас татагч хосолмол ажиллагаатай ПКЛ (Плуг комбинированный лесной) анжсыг Мандал сум дахь Онцгой байдлын хэлтэст 2018 оны 9 дүгээр сард авчран засварлаж ОБЕГ-аас Сэлэнгэ

аймгийн Онцгой байдлын газарт хувиарласан Хятад улсад үйлдвэрлэсэн FOTON LOVOL FT1254 тракторт 2019 оны 4 дүгээр сард тохируулан туршихад хөрсийг 15-20 сантиметрийн гүнтэйгээр 1,4-2 метр шороон зурвас татаж байв. Цаашид ПКЛ болон ПЛП, ПЛЛ, загварын анжсуудыг ой, хээрийн түймэр унтраахад тусгаарлах шороон зурвас татаж түймрийн фонтоос 100-150 метрийн зайнаас угтуулан цуравдах аргаар унтраах ажиллагаанд үр дүнтэй юм.



Дүгнэлт : Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд шаардагдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгаа ” болон энэ чиглэлийн бусад судалгааны асуулгуудад ойн түймэр унтраах гинжит трактор, ойн анжис, машин механизмын судалгаа хамрагдахгүй байна. Цаашид дэлхийн уур амьсгалын дулаарал эрчимтэй явагдаж байгаагаас шалтгаалан ойн сан бүхий аймгуудын түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд хүнд машин, механизм ашиглах зайлшгүй шаардлага бий болж байна.

Ашигласан материал

- 1.Г. Чулуун “Ойн түймэртэй тэмцэх арга” 2015 он
- 2.<http://www.lessnab.com/>
- 3.<http://www.plugi43.ru/>
- 4.Гал түймрийн гамшгийн хохирлыг бууруулахад бүх нийтийн оролцоо сэдэвт хэлэлцүүлгийн эмхэтгэл 2019 он